



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/1384

Мандалговь

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 30 дугаар зүйлийн 30.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын сургуулийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 5 жилийн хугацаатайгаар сунгасугай.

2. Сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах сургууль, цэцэрлэгүүдийн нэрсийг хавсралтаар баталсугай.

3. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгаж, олгохыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ц.Уранбямба)-т зөвшөөрсүгэй.

4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн сургалтын үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, эрх бүхий байгууллагаас тогтоосон стандарт, норм нормативыг сахин мөрдөж байгаад байнгын хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Болор-Эрдэнэ), Боловсрол, шинжлэх ухааны газар (Ц.Уранбямба), Сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4322111256